



**ХЭНТИЙ АЙМАГ
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 4/43

Өмнөдэлгэр сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5, 48 дугаар зүйлийн 48.2, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Гурванбаян тосгоны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх ажлын зураг төсөв хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ж.Энххуяг

Гишүүн: Э.Батхүрэл

Ц.Саранцэцэг

Гурванбаян тосгоны захирагч

Мал аж ахуй хариуцсан
мэргэжилтэн

Төсөв, төрийн сангийн
мэргэжилтэн

2.Холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлыг чанартай гүйцэтгүүлэхийг ажлын хэсгийн ахлагч (Ж.Энххуяг)-д даалгасугай.



Р.ЭНХТӨР

